

Шинэ сэргэлтийн бодлого ба хувийн секторын хүлээлт

З. Манлайбаатар

Д. Оюунтөгс

У. Энхсайхан

С. Отгонбат

Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн (ЭЗСЭШХ)

Хураангуй

“Цар тахлын үеийн эдийн засгийн бодлого: Өнгөрсөн ба ирээдүй” төслийг USAID-ын санхүүжилттэй Хөгжлийн Шийдэл ТББ-ын хэрэгжүүлж буй BEST хөтөлбөрийн захиалгаар 2022 оны 5-р сараас 9-р сарын хугацаанд хэрэгжүүлэв. Төслийн хүрээнд гурван цуврал сэдвээр судалгаа хийж, сэдэв тус бүр дээр хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Энэхүү хоёр дахь судалгаагаар бид УИХ-аас 2021 оны 12-р сард баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын үндэслэл, хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээ, цаашид анхаарах асуудлын талаарх тоймыг хүргэсэн.

Түлхүүр үгс:

Шинэ сэргэлтийн бодлого, хувийн сектор, эрчим хүч, хилийн боомт, аж үйлдвэр, хот хөдөө, ногоон хөгжил, төрийн бүтээмж, Монгол Улс

Улаанбаатар, Монгол

2022



**ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА,
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
ХҮРЭЭЛЭН**

ХӨГЖЛИЙН ШИЙДЭЛ ТББ

ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО БА ХУВИЙН СЕКТОРЫН ХҮЛЭЭЛТ

**УЛААНБААТАР ХОТ
2022 ОН**

Агуулга

Оршил	3
1. Шинэ сэргэлтийн бодлогын зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа	4
2. Эдийн засгийн өсөлтийг хязгаарлагч хүчин зүйлс ба Шинэ сэргэлтийн бодлого	6
2.1. Хилийн боомтын хязгаарлалт	6
Монгол Улсын эдийн засаг болон гадаад худалдааны хамаарал	6
Хил боомт, логиستيкийн салбарын нөхцөл байдал	8
Шинэ сэргэлтийн бодлогод боомтын хөгжлийн талаар туссан арга хэмжээ	10
2.2. Эрчим хүчний хязгаарлалт	11
Цахилгаан эрчим хүчний хэрэглээ	11
Эрчим хүчний үнэ, тариф	13
Сэргээгдэх эрчим хүч	14
Шинэ сэргэлтийн бодлогод эрчим хүчний талаар туссан арга хэмжээ	16
2.3. Аж үйлдвэрийн салбарт тулгамдаж буй асуудал ба шинэ сэргэлтийн бодлого	16
Шинэ сэргэлтийн бодлого ба аж үйлдвэрийн салбар	21
2.4. Хот ба хөдөөгийн хөгжлийн асуудал	23
Хүн амын төвлөрөл, нүүдэл	23
Хот, хөдөөгийн хөгжил ба шинэ сэргэлтийн бодлого	27
2.5. Ногоон хөгжлийн сэргэлт	27
Өнөөгийн байдал	27
Ногоон хөгжлийн талаар баримталж буй бодлого, түүний хэрэгжилт	28
Ногоон хөгжил ба Шинэ сэргэлтийн бодлого	29
2.6. Төрийн бүтээмжийн сэргэлт	30
Төрийн бүтээмжийн өнөөгийн нөхцөл байдал	30
Төрийн бүтээмжийн сэргэлт	34
3. Дүгнэлт, сургамж	36
Ашигласан эх сурвалж	37

Оршил

2020 онд дэлхий дахинд дэгдсэн Ковид-19 цар тахал улс орнуудын хүн амын эрүүл мэнд, эдийн засагт үлэмж хэмжээний хохирол учруулж, үр дагавар нь эдүгээ ч үргэлжилж байна. Манай улсад Ковид-19-ийн бүртгэгдсэн тохиолдол 2022 оны 8-р сарын 25-ны байдлаар 976'751, нас баралт 2'179 хүрээд байна. Цар тахлын улмаас эдийн засаг 2020 онд 4.6% агшсан бол 2021 онд дөнгөж 1.4% өссөн бөгөөд 2022 оны эхний хагаст ч өсөлт тааруу (1.9%) гарав.

Цар тахлын үед Монгол Улсын Засгийн газар эрсдэлийг хязгаарлах, хохирлыг бууруулах, эдийн засгийг сэргээх зорилгоор 2020 оны 4-р сараас эхлээд олон төрлийн багц арга хэмжээг авч хэрэгжүүлж ирсэн. Үүний нэг нь 2021 оны 2-р сард зарласан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх арван их наядын цогц төлөвлөгөө” бөгөөд 2021 он дуустал эрчимтэй хэрэгжүүлсэн энэхүү богино хугацааны арга хэмжээний хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг бид “Эдийн засгийг эрчимжүүлэх 10 их наядын бодлогын хувийн секторт үзүүлсэн үр нөлөө ба хэрэгжилтийн сургамж” судалгааны тайланд тоймлон танилцуулсан билээ.

Дээрх богино хугацааны төлөвлөгөө хэрэгжиж дуусахтай зэрэгцээд Улсын Их Хурал 2021 оны 12-р сарын 30-ны өдрийн хуралдаанаар “Шинэ сэргэлтийн бодлого” тухай 106-р тогтоолыг баталсан. Уг бодлого нь Монгол Улсын эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх, цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэж, урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засаг, дэд бүтэц болон төрийн бүтээмжийг сайжруулахад чиглэсэн дунд хугацааны бодлого юм.

Энэ удаад судалгааны баг Засгийн газраас зарлаад буй уг бодлогын үндэслэл, хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээ, цаашид анхаарах асуудлын талаар энэхүү тайланд тоймлон хүргэж байна.

1. Шинэ сэргэлтийн бодлогын зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа

УИХ-аас 2021 онд баталсан “Шинэ сэргэлтийн бодлого” нь Монгол Улсын эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх, цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэж, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засаг, дэд бүтэц болон төрийн бүтээмжийг сайжруулахад чиглэсэн 2030 он хүртэл хэрэгжих дунд хугацааны зорилтот хөтөлбөр юм.

УИХ-ын тогтоолд дурдсанаар, уг бодлогыг хэрэгжүүлснээр 2030 он гэхэд урт хугацаанд эдийн засгийн өсөлт дунджаар 6 хувьд хадгалагдаж, нэг хүнд ногдох үндэсний орлого 2 дахин нэмэгдэж, ажиллах хүчний оролцооны түвшин 65 хувьд хүрнэ. Боомтын хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлж, эрчим хүчний эх үүсвэрийг 2 дахин өсгөх юм. Эдгээр зорилтыг өмнөх жилүүдийн болон сүүлийн үеийн үзүүлэлтүүдтэй харьцуулсан хүснэгтийг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 1. Шинэ сэргэлтийн бодлогын гол индикаторууд

	1990	2000	2010	2020	2030 зорилт
Нэг хүнд ногдох үндэсний орлого, ам.доллар	1430	470	2000	3740	2 дахин өсгөх
Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн, ам.доллар	1172	474	2643	4060	12054 ¹
Ажиллах хүчний оролцоо, %	75.8	62.9	61.6	58.5	65.0
Хилээр нэвтрүүлсэн ачаа тээвэр, сая тн.					
Төмөр замаар	7.9	5.2	10.5	20.8	3 дахин өсгөх
Автозамаар	-	-	-	30.5	
Эрчим хүчний үйлдвэрлэл, сая кВт.цаг	3348	2946	4312	7070	2 дахин өсгөх

Эх сурвалж: World Development Indicators, Үндэсний Статистикийн Хороо, Зам Тээврийн Хөгжлийн Яам

Шинэ сэргэлтийн бодлогын нэг онцлог нь уг бодлогыг Өсөлтийн оношилгоо (growth diagnostic) хэмээх олон улсад өргөн хэрэглэдэг аргачлалд үндэслэсэн явдал юм. Уг аргачлалыг Rodrik (2004), Hausmann, Rodrik, Velasco (2005) зэрэг судалгаанд анх танилцуулсан. Энэ аргачлал нь эдийн засгийн стандарт онолд суурилдаг бөгөөд эдийн засгийн өсөлтөд богино хугацаанд нөлөөлж байгаа хязгаарлагч хүчин зүйлсийг тодорхойлдог. Жишээлбэл тухайн улс ерөнхий эрсдэл өндөр, бизнесийн

¹ 2022 оны 4-р сард зохион байгуулсан Эдийн засгийн форум дээр Шинэ сэргэлтийн бодлогын талаарх Ерөнхий сайдын танилцуулгаас авав.

орчин муу, өр ихтэй, зах зээлийг төрөөс хэт зохицуулдаг байвал гадаадаас хөрөнгө татахад хэцүү болно. Дэд бүтцийн хөгжил тааруу, хүмүн капиталдаа хөрөнгө оруулдаггүй бол хөрөнгө оруулалтын өгөөж муу байна. Байгалийн нөөцөө муу удирддаг бол газрын өгөөж муу болно. Татвар өндөр, өмчлөх эрхийн хамгаалалт сул, авлига их, макро эдийн засаг тогтворгүй бол бол хөрөнгө оруулалтын өгөөж муудаж хөрөнгө оруулалт хийгдэхгүй, улмаар технологи хоцрогдож, урт хугацааны эдийн засгийн өсөлт саарна. Энэ мэт хязгаарлагч хүчин зүйлсийг зөв оношилж тогтоох Hausmann, Rodrik, Velasco нарын аргачлалыг дараах схемээр товч илэрхийлж болно (Ianchovichina & Gooptu, 2007).



Анх Ianchovichina, Gooptu (2007) судалгаанд 2000-аад оны дунд үеийн Монголын эдийн засгийн өсөлтийн оношилгоог дээрх аргаар гүйцэтгэж, Азийн бусад орны нөхцөл байдалтай харьцуулсан байдаг. Тухайн үеийн дүгнэлтээр, Монгол Улсад санхүүжилтийн бэрхшээл бага боловч хөрөнгө оруулалт зөвхөн уул уурхай, барилга руу чиглэсэн, бусад салбарт ашиг багатай тул хөрөнгө оруулалт бага хийгдэж байжээ. Тээврийн зардал их, логистик найдваргүй, гааль, худалдааны дүрэм журам төвөгтэй, татвар тэгш бус, уялдаа зохицуулалт муу, авлига их зэрэг нь гол хязгаарлагч хүчин зүйлс болж байв. Мөн санхүүгийн зуучлалын үйлчилгээ тааруу учраас зээлийн хүү өндөр байв.

Тэгвэл 2021 онд Монгол Улсын Засгийн газар Өсөлтийн оношилгоо шинжилгээнд үндэслэн, улс орны эдийн засгийн өсөлтийг хязгаарлагч хүчин зүйлсийг дахин үнэлжээ. Энэ үнэлгээгээр тодорхойлогдсон хязгаарлагч хүчин зүйлсийг 6 багц болгон томъёолж, Шинэ сэргэлтийн бодлогоо боловсруулжээ. Энэхүү 6 багц асуудлын өнөөгийн нөхцөл байдал болон Шинэ сэргэлтийн бодлогод дэвшүүлсэн зорилтуудын талаар дараах бүлэгт дэлгэрэнгүй авч үзье.

2. Эдийн засгийн өсөлтийг хязгаарлагч хүчин зүйлс ба Шинэ сэргэлтийн бодлого

2.1. Хилийн боомтын хязгаарлалт

Эдийн засгийн онцлогоосоо шалтгаалан Монгол Улс нь гадаад худалдаанаас хэт хамааралтай. Тухайлбал, Монгол Улсын эдийн засаг нь уул уурхайн салбарт тулгуурласан буюу тухайн салбар нь нийт эдийн засгийн 20 гаруй хувь, нийт экспортын 90 орчим хувийг бүрдүүлдэг. Дотоодын эдийн засаг жижиг, аж үйлдвэр хөгжөөгүйн улмаас олборлосон бүтээгдэхүүний ихэнх хэсгийг гадагшаа экспортолдог. Үүнтэй адил шалтгаанаар ихэнх тоног төхөөрөмж, хүнсний бүтээгдэхүүн болон бусад барааг гадаадаас импортолдог.

Тэгвэл улс орнуудад эрдэс баялгийн бүтээгдэхүүнээ чөлөөтэй экспортолж, тоног төхөөрөмж, хүнсний бүтээгдэхүүнээ саад тотгоргүй импортолж байхын тулд хил боомтын хүчин чадал өндөр, мөн үр дүнтэй тээвэр, логистикийн үйл ажиллагаа зайлшгүй шаардлагатай. Гэтэл одоог хүртэл ердөө 3 хилийн боомт төмөр замтай, гол худалдааны түнш болох Хятад улстай төмөр замын цариг ялгаатай мөн бусад хилийн боомтуудын төмөр зам хангалттай сайн хөгжөөгүй байна. Иймээс хилийн боомтууд дээр тогтмол асуудлууд үүсэж, экспорт болон импортыг хязгаарласнаар эдийн засгийн өсөлтийг удаашруулж, үнийн өсөлтийг хөөрөгдүүлэн тодорхой бус байдлыг нэмэгдүүлдэг. Тухайлбал, манай улсын бараа бүтээгдэхүүний үнийн бүтцийн 30 орчим хувийг тээвэр, логистикийн зардал эзэлж байна (ADB, 2018).

Монгол Улсын эдийн засаг болон гадаад худалдааны хамаарал

2006 оноос Монгол Улсын уул уурхайн салбар эрчимжиж эхэлсэн бөгөөд 2009 онд Оюутолгой ашиглалтад орсноор манай улсын гадаад худалдаанаас хамаарах хамаарал улам нэмэгдэж, өндөр хүчин чадалтай хилийн боомт, үр дүнтэй тээвэр логистикийн үйл ажиллагаатай байх шаардлага гарч ирсэн.


Зураг 1. Монгол Улсын гадаад худалдааны танилцуулга




Эх сурвалж: YCX

Уул уурхайн бүтээгдэхүүний ихэнх хувийг экспортолдог, дотоодын хэрэглээнд импортын бараа бүтээгдэхүүн давамгайлдаг улсын хувьд гадаад худалдаа маш чухал юм. Ковид-19 өмнө буюу 2019 онд гадаад худалдаа эргэлт буюу экспорт болон импортын нийлбэр ДНБ-ий 120 гаруй хувьтай тэнцүү байсан (Зураг 3). Энэ нь манай улстай ижил төстэй орон болох Казакстанаас 2 дахин, Монгол улсын гол худалдааны хөршүүд болох Хятад болон Орос улсуудаас 3-4 дахин өндөр үзүүлэлт юм (Зураг 4).

Зураг 2. Монгол Улсын гадаад худалдааны эргэлт ба ДНБ-ий харьцаа




Зураг 3. Гадаад худалдааны эргэлт ба ДНБ-ий харьцаа, улсаар, 2019 он




Эх сурвалж: УСХ, Дэлхийн Банкны мэдээллийн сан

Нийт экспортын 90 орчим хувийг дан ганц уул уурхайн бүтээгдэхүүний экспорт бүрдүүлдэг, мөн нийт экспортын дийлэнх хувийг БНХАУ руу гаргадаг. Харин экспортын бараа бүтээгдэхүүнээ тээвэрлэхдээ задгайгаар буюу авто замаар тээвэрлэдэг. Гэвч харамсалтай нь хилийн боомтуудаа гол уурхайнуудтайгаа холбосон зам тээвэр хангалттай хөгжөөгүй хэвээр л байна.

Зураг 4. Нийт экспорт, 2019 он




Зураг 5. Экспорт, тээврийн төрлөөр, хувиар, 2019 он




Эх сурвалж: Монголбанк, УСХ (2019)

Монгол Улс нь хүнсний бүтээгдэхүүн, ахуйн бараа, гэрийн цахилгаан бараа, хувцас, гоо сайхны бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, автомашин, бензин, дизель түлш зэрэг бүтээгдэхүүний дотоодын хэрэглээний ихээхэн хэсгийг импортоор авч байна. Экспортоос ялгаатай нь импортын бүтээгдэхүүнийг голчлон төмөр замаар тээвэрлэж байна. Импортын гол түнш орууд нь БНХАУ (2019 оны байдлаар 33.2%), ОХУ (28.2%) болон Япон Улс (9.6%) юм. 2019 оны байдлаар ОХУ-аас импортолсон барааны 62.0 хувийг нефтийн бүтээгдэхүүн, Япон Улсаас импортолсон барааны 60.9 хувийг суудлын автомашин, БНХАУ-аас импортолсон барааны 5.7 хувь нь цахилгаан эрчим хүч, 13.9% нь ачааны тэрэг, үлдсэн хувийг олон нэр төрлийн бага жинтэй, бараа бүтээгдэхүүнүүд эзэлж байжээ (ҮСХ, 2019).

Зураг 6. Нийт импорт, 2019 он



Зураг 7. Импорт, тээврийн төрлөөр, хувиар, 2019 он



Эх сурвалж: Монголбанк, ҮСХ (2019)

Логистикийн салбар нь гадаад худалдааны гол тулгуур бөгөөд сайн логистик нь худалдааны зардлыг бууруулж улс орнуудад гадаад зах зээлд өрсөлдөх боломжийг олгодог. Ялангуяа гадаад худалдаанаас хэт хамааралтай манайх шиг орны хувьд логистикийн салбар нь өндөр хөгжсөн байх шаардлагатай. Гэвч манай орны логистикийн салбарын хөгжил маш доогуур, төрөөс баримталж байгаа бодлого хангалтгүй байсаар ирсэн. Дараагийн хэсэгт хил боомт, логистикийн салбарын өнөөгийн нөхцөл байдлын талаар авч үзлээ.

Хил боомт, логистикийн салбарын нөхцөл байдал

Гадаад худалдааны ихээхэн хамаарлаас шалтгаалан Монгол Улсын эдийн засаг тогтвортой байхын тулд зайлшгүй хил боомт, логистикийн нөхцөл байдал маш сайн байх ёстой. Гэтэл Дэлхийн банкнаас гаргадаг Логистикийн гүйцэтгэлийн индекс (LPI)-ээр 2018 онд Монгол Улс 160 орноос 130-д эрэмбэлэгджээ (The World Bank, 2018).

2010-2018 оны хооронд LPI-ийг хэмждэг зургаан үзүүлэлтээс гааль болон цаг хугацаа гэсэн хоёр үзүүлэлтэд багахан ахиц гарсан байна. Энэ нь гаалийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр сүүлийн жилүүдэд засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдтэй холбон тайлбарлаж болно. Гэхдээ ахиц дэвшил тийм ч хангалттай биш байна. Харин дэд бүтэц, олон улсын ачаа тээвэр, логистикийн өрсөлдөх чадвар болон ачаа тээвэрлэлтийн мэдээлэл зэрэг үзүүлэлтүүдэд ямар ч ахиц дэвшил гараагүй, зарим үзүүлэлтийн хувьд буурсан байна. Эдгээр үзүүлэлтүүд хангалтгүй байгаа нь Монгол Улсын логистикийн нийлүүлэлтийн гинжин сүлжээнд, тээвэр, логистикийн дэд бүтэц

маш сул байгааг илтгэнэ. Засгийн газраас тээвэр, логиستيкийг сайжруулах тал дээр төрөл бүрийн арга хэмжээ хэрэгжүүлсээр ирсэн ч ахиц дэвшил бараг л гараагүй байна.


Хүснэгт 2. Монгол Улсын Логистикийн гүйцэтгэлийн индекс (LPI)

		2010	2012	2014	2016	2018
LPI ерөнхий үзүүлэлт	Оноо	2.3	2.3	2.4	2.5	2.4
LPI эзлэх байр	Байр	141	140	135	108	130
Гааль	Оноо	1.8	2.0	2.2	2.4	2.2
	Байр	149	144	132	100	127
Дэд бүтэц	Оноо	1.9	2.2	2.3	2.1	2.1
	Байр	133	125	120	140	135
Олон улсын ачаа тээвэр	Оноо	2.5	2.1	2.6	2.4	2.5
	Байр	119	142	110	129	117
Логистикийн өрсөлдөх чадвар	Оноо	2.2	1.9	2.3	2.3	2.2
	Байр	128	152	126	129	140
Ачаа тээвэрлэлтийн мэдээлэл	Оноо	2.4	2.3	2.1	2.5	2.1
	Байр	122	134	149	108	152
Цаг хугацаа	Оноо	2.6	3.0	2.5	3.4	3.1
	Байр	147	97	147	65	93


Эх сурвалж: Дэлхийн Банкны Логистикийн гүйцэтгэлийн индекс

Мөн Дэлхийн Банкнаас “Бизнес эрхлэхүй” тайланг жил бүр гаргадаг бөгөөд энэхүү тайлангаараа дэлхийн хаана бизнес эрхлэхэд хамгийн таатай талаар танилцуулдаг. Энэхүү үзүүлэлтийг гаргахдаа нийт 10 бүлэг үзүүлэлтээр үнэлдэг бөгөөд үүний нэг нь “Хил дамнасан худалдаа” юм. Орнуудын хил дамнасан худалдааг харьцуулахдаа экспорт, импорт хийх хугацаа болон зардлыг ашигладаг. 2020 оны байдлаар Монгол Улс хил дамнасан худалдаагаараа 190 орноос 143-т эрэмбэлэгджээ.

Зураг 8. Экспорт хийх хугацаа (цаг), улсаар



Зураг 9. Экспорт хийх зардал (ам.доллар), улсаар




Эх сурвалж: Дэлхийн Банк: Бизнес Эрхлэхүй (2020)

Экспорт хийхэд зарцуулж байгаа хугацаагаараа гол худалдааны хоёр улс болон Казахстан улстай харьцуулахад нэлээд өндөр байна (Зураг 8). Тухайлбал, экспорт хийхэд зарцуулж буй нийт хугацаагаар (хил нэвтрэх болон бичиг баримт бүрдүүлэхэд зарцуулж буй хугацаа) Монгол нь Казахстан улсаас 29.6 хувиар, Оросоос даруй 3 дахин, Хятадаас 10 дахин өндөр байна. Цаашлаад

бичиг баримт бүрдүүлэх цаг нь хил нэвтрэх цагаас өндөр байгаа нь гаальд нэн даруй шинэчлэл хийх шаардлагатайг харуулж байна. Харин экспорт хийхэд гардаг мөнгөн зардлын тухайд энэхүү улсуудтай харьцуулахад нэлээд бага байна.

Импорт хийхэд хил нэвтрэх хугацааны хувьд Орос болон Хятад улсуудтай ойролцоо байгаа боловч бичиг баримт бүрдүүлэхэд Хятадаас бараг 10 дахин, Казакстанаас ойролцоогоор 20 дахин өндөр байна. Харин зардлын хувьд Хятад болон Орос улсуудаас нэлээд бага байгаа боловч Казакстан улсаас нэлээд өндөр байна. Импортын бүтээгдэхүүний үнэ инфляцад хүчтэй нөлөө үзүүлдэг манай орны хувьд импорт хийхэд гардаг зардлыг аль болох бууруулах шаардлагатай.

Зураг 10. Импорт хийх хугацаа (цаг), улсаар



Зураг 11. Импорт хийх зардал (ам.доллар), улсаар



Эх сурвалж: Дэлхийн Банк: Бизнес Эрхлэхүй (2020)

Шинэ сэргэлтийн бодлогод боомтын хөгжлийн талаар туссан арга хэмжээ

2022 оны 4-р сард зохион байгуулсан Монголын Эдийн засгийн форум дээр Шинэ сэргэлтийн бодлогын талаарх Ерөнхий сайдын танилцуулгад хилийн боомтын дээрх асуудлыг дүгнэхдээ, манай улсын экспортын ачааны 90% нь 3 боомтоор, импортын 90% нь 2 боомтоор гардаг бөгөөд ДНБ-д эзлэх тээвэр логиستيкийн зардал 26% буюу дэлхийн дунджаас 2 дахин их байдгийг онцолсон.

Хилийн боомтын сул хөгжлөөс шалтгаалсан дээрх хүндрэлүүдийг дунд хугацаанд шийдэхийн тулд Шинэ сэргэлтийн бодлогын эхний багц арга хэмжээ болох “Боомтын сэргэлт” хөтөлбөрт дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- Боомтуудын хатуу, зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэн ачаа болон зорчигч нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлж, экспортыг 3 дахин нэмэгдүүлэх. Үүний тулд 2022-2024 онд экспортын хил нэвтрэлтийг 70 сая тн, 2025-2028 онд 80 сая тн, 2029 оноос хойш 95 сая тн-д хүргэж өргөтгөнө.
- Хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр, логиستيкийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг

сайжруулж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлэх. Үүнд үндэсний төмөр замын сүлжээг 2 дахин уртасгах, боомтыг холбосон 2966 км автозам барих, Алтанбулаг-Замын-Үүдийг холбосон 987 км хурдны зам барина.

- Монгол Улсын агаарын зайн зохион байгуулалт, агаарын замын ашиглалтыг сайжруулан дамжин өнгөрөх агаарын хөлгийн тоог нэмэгдүүлж, агаарын тээврийн либералчлалыг үе шаттайгаар үргэлжлүүлэх замаар ачаа тээврийн зангилаа төвийг бий болгож, мөн аялал жуулчлалын салбарыг дэмжих. Үүний тулд идэвхтэй үйл ажиллагаатай агаарын боомтын тоог 2 дахин нэмэх, 4С ангиллын нисэх буудлыг 4 болгож нэмэгдүүлнэ.
- Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан эдийн засгийн чөлөөт бүс, хуурай боомтуудыг үе шаттайгаар байгуулах замаар худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх. Энд Алтанбулаг, Замын-Үүд, Сайншанд, Улаанбаатарыг хуурай боомт, Замын-Үүд, Ханги, Гашуунсухайт, Шивээхүрэн, Хавирга, Ульханы боомтуудыг аялал жуулчлалын боомт болгон хөгжүүлнэ.

2.2. Эрчим хүчний хязгаарлалт


Эрчим хүчний салбар нь улс орны хөгжлийн чухал суурь нөхцөл болдог. Монгол Улсын хувьд эрчим хүчний хэрэглээгээ дотоодоосоо бүрэн хангах боломжгүй тул жил бүр хэрэглээнийхээ 20%-ийг хөрш орнуудаасаа импортолдог. Тухайлбал, импортоор авч буй цахилгаан эрчим хүчний 80 гаруй хувийг Оюу Толгой компани БНХАУ-аас, үлдсэн хэсгийг Төвийн болон баруун бүсийн систем ОХУ-аас авдаг байна. Өөрөөр хэлбэл манай улсын эрчим хүчний салбар гаднын орноос хараат байдалд байна.

Цахилгаан, дулааны эрчим хүчний хэрэглээ жилд 6-7%-аар тогтмол өсөж, оргил ачаалал нэмэгдсээр байна. Мөн Монгол Улсын цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний насжилт 32-62 жил, дулааны станцуудын насжилт 35-60 жил бөгөөд эрчим хүчний системийн 40 орчим хувь нь ашиглалтын хугацаа дууссан. Гэтэл хөрөнгийн эх үүсвэрийн дутагдалтай холбоотойгоор шаардлагатай засвар, шинэчлэлийн ажлууд бүрэн хийгдэх боломжгүй болж, дулааны цахилгаан станцуудын болон цахилгаан шугам сүлжээний гэмтэл, саатал нэмэгджээ. Иймээс цахилгаан эрчим хүчний суурь хүчин чадлыг нэмэгдүүлэх, нэмэлт эх үүсвэрүүдийг барьж, байгуулах шаардлага тулгараад байна.

Цахилгаан эрчим хүчний хэрэглээ

Эрчим хүчний зохицуулах хорооны мэдээлснээр Монгол Улсын цахилгаан эрчим хүчний 2021 оны хэрэглээ 2017 онтой харьцуулахад 28.4%-аар өссөн бөгөөд жилд импортолдог цахилгаан эрчим хүчний хэмжээ мөн хугацаанд 22.3%-аар нэмэгджээ. Мөн дотоодын цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл 30.0%-аар өсжээ.


Зураг 12. Монгол Улсын цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл, импорт, хэрэглээ, сая кВт.ц



Эх сурвалж: Эрчим хүчний зохицуулах хороо, (Эрчим хүчний зохицуулах хороо, 2022)

2021 онд Монгол Улсын цахилгаан эрчим хүчний хэрэглээ 9,775.4 сая кВт.ц-т хүрч, өмнөх оноос 10.4%-аар огцом нэмэгджээ. Үүний 1,861.8 сая кВт.ц-ыг импортоор авсан. Ийнхүү хэрэглээний өсөлт хурдассан нь цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан Засгийн газраас хэрэглэгчдийн цахилгаан, дулааны эрчим хүчний хэрэглээний төлбөрийг төрөөс хариуцахаар шийдвэрлэсэнтэй холбоотой. Мөн цахилгаан, дулаан үнэгүй хэрэглэх болсон нь оргил ачааллыг огцом нэмэгдүүлжээ (Зураг 13).

Зураг 13. Монгол Улсын жилийн цахилгаан эрчим хүчний оргил ачаалал, МВт



Эх сурвалж: Эрчим хүчний зохицуулах хороо, (Эрчим хүчний зохицуулах хороо, 2022)

Өвлийн оргил ачаалал 2021 онд 1387 МВт-д хүрч, 2017 онтой харьцуулахад 36.5%-аар, хөнгөлөлтөөс өмнөх 2019 оны оргил ачаалалтай харьцуулахад 20.3%-аар өсжээ. 2021 оны өвлийн оргил ачааллын үед хэрэглээний 12.4% буюу 172 МВт-ийг импортоор авсан байна. Импортын цахилгаан эрчим хүчний авч болох дээд хязгаар 245 МВт байдаг. Энэ хандлагаараа оргил ачааллын хэмжээ нэмэгдвэл импортын дээд хязгаарт хүрэх эрсдэлтэй. Иймээс эрчим хүчний нэмэлт эх үүсвэр байгуулах шаардлага тулгарч байна.

Төрөөс эрчим хүчний тухай баримтлах бодлого (2007), Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны үндэсний хөтөлбөр (2018) зэрэг олон бодлогын баримт бичгүүдэд цахилгаан эрчим хүчний нэмэлт эх үүсвэрийг барих тухай тусгасаар ирсэн. Хамгийн сүүлд Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Тавантолгой, Багахангайн цахилгаан станцыг барих,


Дулааны 3-р станцыг өргөтгөх зэрэг эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажлыг төлөвлөжээ. Нэмэлт эх үүсвэрийг байгуулснаар эрчим хүчээ дотоодоосоо бүрэн хангах төдийгүй эдийн засгийн хувьд ихээхэн эерэг нөлөөтэй. Тухайлбал, эрчим хүчний 5 дахь эх үүсвэрийг байгуулснаар хөдөлмөрийн зах зээл, улсын төсөвт нөлөөлөөд зогсохгүй, ДНБ-ий өсөлтөд ойролцоогоор 1%-ийн эерэг нөлөө үзүүлнэ (ЭЗСЭШХ, 2014). Гэхдээ үнэ, тарифын тогтолцоогоо сайжруулж, эрчим хүчний үнийг чөлөөлөх хэрэгтэй.

Эрчим хүчний үнэ, тариф


Эрчим хүчний салбарт тулгамдаад буй асуудлуудын нэг бол үнэ, тарифын асуудал юм. Эрчим хүчний зохицуулах хорооны мэдээлснээр, 2021 оны байдлаар Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний цахилгаан эрчим хүчний нэгжийн өртөг 182.29 төг/кВт.ц байдаг бол хэрэглэгчийн төлдөг дундаж үнэ 174.22 төг/кВт.ц байна. Өөрөөр хэлбэл хэрэглэгчид үйлдвэрлэсэн өртгөөс 8.07 төг/кВт.ц-аар хямд үнэтэй эрчим хүч хэрэглэдэг. Энэ нь төрөөс эрчим хүчний үнийг барих бодлого хэрэгжүүлдэгтэй холбоотой.

Тарифын ангиллаар авч үзвэл Уул уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэрийн дундаж тариф өртгөөс 5.0%-аар, аж ахуйн нэгж, байгууллага 25.0%-аар, орон сууцны айл өрх 50.0%-аар, гэр хорооллын айл өрх 59.0%-аар тус тус доогуур үнэ тарифыг мөрдөж байна. Ингэснээр эрчим хүчний компаниуд алдагдалтай ажиллаж байна. Сүүлийн 5 жилд эрчим хүчний компаниудын үйл ажиллагааны алдагдал 5.8 дахин нэмэгдэж, 2021 оны байдлаар 77.8 тэрбум төгрөгт хүрсэн. Мөн хугацаанд Улсын төсвөөс эрчим хүчний компаниудад олгодог татаас 1.5 дахин нэмэгдэж, 2021 онд 25.2 тэрбум төгрөгт хүрчээ. (Эрчим хүчний зохицуулах хороо, 2022).

Зураг 14. Улс орнуудын цахилгаан эрчим хүчний үнийн харьцуулалт, ам.цент/кВт.ц²



Зураг 15. Төвийн бүсийн цахилгааны үнийн өөрчлөлт, төг/кВт.ц³



Эх сурвалж: Эрчим хүчний зохицуулах хороо, (Эрчим хүчний зохицуулах хороо, 2022)

² 1 ам.доллар=2849.89 төг

³ Энгийн тоолууртай хэрэглэгчдийн хувьд


Монгол Улсын эрчим хүчний үнийг Азийн зарим орнууд болон Эрчим хүчний зохицуулагчдын бүсийн нийгэмлэгийн орнуудтай харьцууллаа (Зураг 14). Манай улс эрчим хүчээ дотоодоосоо бүрэн хангах боломжгүй ч бусад орнуудаас бага үнээр хэрэглэдэг. Тухайлбал, БНХАУ-аас 1.5-1.6 дахин, Словакаас 2.6-3.6 дахин бага үнээр хэрэглэж байна. Энэ нь эрчим хүчний үнийн бодлого, аргачлалтай шууд холбоотой. Эрчим үйлдвэрлэх, түгээх өртөгт нүүрсний үнэ, валютын ханш, хэрэглэгчийн үнийн индекс, үйлдвэрлэгчийн үнийн индекс зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг. Гэвч манай улсын хувьд эдгээр хүчин зүйлсийн өөрчлөлттэй уялдуулан үнийг тогтоодоггүй, 2-3 жилдээ нэг удаа үнийг шинэчилдэг (Зураг 15). Энэ нь эрчим хүчний компаниудын алдагдлын гол шалтгаан болж байна. Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд үнэ тарифын тогтолцоонд шинэчлэл хийж, үнэ тарифыг улирал бүр өөрчлөгддөг байхаар индексжүүлэн тогтоохоор тусгажээ.

Сэргээгдэх эрчим хүч

Дэлхий нийтээр нүүрсний эх үүсвэртэй цахилгаанаас татгалзаж, байгальд ээлтэй сэргээгдэх эрчим хүч рүү шилжиж байна. Дэлхийн эрчим хүчний холбооны мэдээлснээр 2021 оны байдлаар цахилгаан эрчим хүчний эх үүсвэрийн 30 орчим хувийг сэргээгдэх эрчим хүч бүрдүүлж байна (Олон улсын эрчим хүчний холбоо, 2021).

Монгол Улсын хувьд сэргээгдэх эрчим хүчний асар их нөөцтэй. Энэ давуу талаа ашиглан, эрчим хүчний хэрэгцээгээ хангах, улмаар экспортлох боломжтой юм. Одоогийн байдлаар Монгол Улсын нэгдсэн системд 3 салхин цахилгаан станц, 6 нарны цахилгаан станц, 4 усан цахилгаан станц ажиллаж байна. Эдгээрийн үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүч 2021 оны байдлаар нийт эрчим хүчний үйлдвэрлэлийн 10.1%-ийг бүрдүүлсэн. Бүтцээр авч үзвэл, салхин цахилгаан станц 70.1%-ийг, нарны эх үүсвэр 19.5%-ийг, усан цахилгаан станц 10.4%-ийг үйлдвэрлэжээ.

Зураг 16. Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, сая кВт.ц



Эх сурвалж: Эрчим хүчний зохицуулах хороо, (Эрчим хүчний зохицуулах хороо, 2022)

Сүүлийн 5 жилд сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл 3.1 дахин нэмэгдсэн боловч Монгол Улсын эрчим хүчний дийлэнх хэсгээ нүүрсний эх үүсвэртэй эрчим хүчнээр хангасаар байна. Тодруулбал, Монгол Улс Азийн хөгжлийн банкны гишүүн орнууд дундаас нүүрснээс хамгийн их хамааралтай улсаар нэрлэгджээ (Азийн хөгжлийн банк, 2020). Нөгөө талаас, Монгол Улсад сэргээгдэх эрчим хүчний салбарыг хөгжүүлэхийн тулд бодлогын арга хэмжээнүүд авах шаардлагатай байна.

Зураг 17. Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, төрлөөр, сая кВт.ц

	2017	2018	2019	2020	2021
Нарны цахилгаан станц	19.7	51.5	109.0	108.9	156.9
Усан цахилгаан станц	84.5	78.2	85.4	83.3	83.1
Салхин цахилгаан станц	154.4	339.0	459.3	457.2	563.0
Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл	258.6	468.7	653.7	649.4	803.0

Эх сурвалж: Эрчим хүчний зохицуулах хороо, (Эрчим хүчний зохицуулах хороо, 2022)

Анх 2007 онд “Сэргээгдэх эрчим хүчний тухай” хуулийг баталж, тус хуулиар сэргээгдэх эрчим хүчний үнийг тогтоож өгсөн. Үүнд:

- Салхины эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэж нийлүүлэх 1 кВтц цахилгаан эрчим хүчийг 0.085 ам.доллар хүртэл (271.46 ⁴төг/кВт.ц)
- 5000 кВт хүртэл хүчин чадалтай усан цахилгаан станцын үйлдвэрлэж нийлүүлэх 1кВт.ц цахилгаан эрчим хүчийг 0.045-0.06 ам.доллар (143.72 -191.62 төг/кВт.ц)
- Нарны эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэж нийлүүлэх 1 кВт.ц цахилгаан эрчим хүчийг 0.12 ам.доллар хүртэл (393.24 төг/кВт.ц)

Сэргээгдэх эрчим хүчний үнийг ам.доллороор тогтоосон нь валютын ханшийн өсөлтөөс шалтгаалан үнэ өсөх нөхцөлийг бүрдүүлжээ. 2015 онд тус хуульд нэмэлт өөрчлөлт оруулан, үнийн зөрүүг дэмжих тарифаар нөхөн олгож эхэлсэн. 2015 онд дэмжих тарифыг 1кВт.ц цахилгаан тутамд 4 төгрөгөөр тогтоож байсан бол 2022 оны байдлаар 23.79 төг/кВт.ц-т хүрчээ. (Эрчим хүчний зохицуулах хороо, 2019). Энэхүү зохицуулалт нь сэргээгдэх эрчим хүчний үнийг нэмэгдүүлээд зогсохгүй, нийт систем дахь сэргээгдэх эрчим хүчний хэмжээ нэмэгдэх тусам үүсэх дарамтыг хэрэглэгчдэд үүрүүлж байна. Гэхдээ сэргээгдэх эрчим хүчний үнэ өндөр байгаа нь гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд таатай нөхцөл бүрдэж, хөрөнгө оруулагчдыг татдаг.

Дараагийн нэг асуудал бол сэргээгдэх эрчим хүчний зохистой харьцаа юм. Сэргээгдэх эрчим хүч нь байгалийн нар салхийг ашиглан цахилгаан үйлдвэрлэдэг тул цаг уурын нөхцөл байдалтай ихээхэн хамааралтай. Гэвч нарны цахилгаан станцын хувьд нар тусах цагаар эрчим хүч үйлдвэрлэх бол салхин цахилгаан станц салхигүй үед эрчим хүч нийлүүлэхгүй. (Эрчим хүчний зохицуулах хороо, 2019). Өөрөөр хэлбэл наргүй, салхигүй өдөр эдгээр сэргээгдэх эрчим хүчний станцын нийлүүлэх эрчим хүчийг өөр эх үүсвэрээс хангах хэрэгтэй болно. Хэрэв одоогийн нэгдсэн системд нар салхины сэргээгдэх эрчим хүчний нийлүүлэлт 245 МВт (ОХУ-аас импортоор авах дээд хэмжээ)-аас үед тохируулах хийхэд ихээхэн хүндрэл үүснэ.

Харин байгалийн хүчин зүйлээс хамаарч үйл ажиллагаа гэнэт саатах эрсдэл харьцангуй багатай нь усан цахилгаан станц юм. Гэвч усан цахилгаан станц байгуулснаар гол мөрний урсац багасах, зэргээр экологийн орчинд ихээхэн нөлөө үзүүлдэг. Иймээс нийгмийн зүгээс ирэх эсэргүүцэлтэй

⁴ 1 ам. доллар =3193.69 төг

тулгардаг. Тухайлбал, Монгол Улсын усан цахилгаан станцын томоохон төсөл болох Эгийн голын усан цахилгаан станц баригдсанаар ОХУ-ын Сэлэнгэ мөрөн, Байгаль нуурын усны нөөцөд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй тул нарийн судалгаа хийх шаардлагатай хэмээн ОХУ-ын талаас усан цахилгаан станцын төслийг эсэргүүцсэн. Энэ нь байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлсэн үйлдэл байж болох ч манай улсад эрчим хүч нийлүүлдэг улсын зүгээс тавьсан хориг байж болзошгүй юм. Харин энэхүү усан цахилгаан станц баригдсанаар Сэлэнгэ мөрөн, Байгаль нуурт ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй гэсэн дүгнэлт гарчээ (Эрчим хүчний яам, 2022). Ингэснээр энэхүү төсөл үргэлжлэх нөхцөл бүрдсэн. Түүнчлэн, Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Эгийн голын усан цахилгаан станцын ажлыг цааш үргэлжлүүлэх талаар тусгасан. Мөн тус бодлогын хүрээнд Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын төслийг эрчимжүүлж, ашиглалтад оруулан баруун бүсийн хэрэглэгчдийг эрчим хүчээр хангах ажлыг хийхээр төлөвлөжээ. Оргил ачааллын үед тохируулга хийхэд ашиглах, цэнэг хураагуурыг барих ажлыг хийхээр төлөвлөсөн. Энэхүү байгууламж ашиглалтад орчноор нарны болон салхин цахилгаан станцын хуримтлуулсан цэнэгийг оргил ачааллын үед ашиглан, эрчим хүчний тохируулга хийхэд ашиглах боломжтой болно. Түүнчлэн тус бодлогын хүрээнд Өмнийн говьд салхи болон нарны цахилгаан станц байгуулан Азийн эрчим хүчний сүлжээнд нийлүүлэх талаар нарийн судалгаануудыг хийх ажлыг эхлүүлэх юм.

Шинэ сэргэлтийн бодлогод эрчим хүчний талаар туссан арга хэмжээ

- Эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх шугам сүлжээг шинээр барьж байгуулан хүчин чадлыг өргөтгөн нэмэгдүүлж, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлэх
- Сэргээгдэх эрчим хүчийг зохистой харьцаагаар хөгжүүлэн усан болон хуримтлуурын станц барьж, эрчим хүчний нэгдсэн системийн найдвартай, тогтвортой байдлыг хангах
- Эрчим хүчний салбарыг санхүү, эдийн засгийн бие даасан тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлэх
- Зүүн хойд Азийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд эрчим хүч нийлүүлэх сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, сүлжээнд холбогдох хэт өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын бэлтгэл ажлыг хангах
- Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу Монгол Улсын газар нутгаар дамжин өнгөрөх байгалийн хий дамжуулах хоолойг барих бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх.


2.3. Аж үйлдвэрийн салбарт тулгамдаж буй асуудал ба шинэ сэргэлтийн бодлого

Аж үйлдвэрийн салбар нь Монгол улсын эдийн засгийн хөгжилд голлох байр суурь эзэлдэг хөгжлийн тэргүүлэх чиглэл юм. 1990-ээд онд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэнтэй холбоотойгоор социализмын үед байгуулагдсан аж үйлдвэрийн салбар уналтад орсон билээ. Үүний үр дүнд эдийн засаг бүтцийн өөрчлөлтөд орж, аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь эрс буурсан билээ. 1990 онд уул уурхайн бус аж үйлдвэрийн салбар ДНБ-ий 29%-ийг эзэлж байсан бол энэ хувь буурсаар 2021 оны байдлаар дөнгөж 12% болжээ. Харин энэ хугацаанд уул уурхайн салбарын эзлэх хувь 12%-аас 25% болж тэлсэн. Өөрөөр хэлбэл, манай улсын эдийн засаг уул уурхайн салбараас хэт хамааралтай болоод байна.

Манай улсын хувьд уул уурхайн бүтээгдэхүүнээ түүхийгээр экспортолдог, мал аж ахуйн орон атлаа түүнээс гарах бүтээгдэхүүн үйлдвэрлэл, боловсруулалт байхгүй, хүнсний болон бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл дотоодынхоо хэрэгцээг хангаж дийлдэггүй буюу аж үйлдвэрийн салбар дахь экспортын бүтээгдэхүүний 95 орчим хувь нь уул уурхай, хөдөө аж ахуйн түүхий эд хялбар технологи дээр суурилсан анхан шатны боловсруулалт хийсэн түүхий эд юм. Монгол Улс байгалийн баялгийнхаа 90 хувийг боловсруулалгүй хямд үнээр гаргаж, дотоодын хэрэглээнийхээ 90 хувийг гадаадаас худалдан авч байгаа нь аж үйлдвэржилтийн бодлого алдагдсаны гашуун сургамж юм. Иймд уул уурхайн салбараас хэт хамааралтай болж буй манай орны хувьд эдийн засгийг төрөлжүүлж, дотоодын хэрэгцээг импортлогч улсуудаас хараат бусаар хангах, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай болгож, шинэ бүтээгдэхүүн бий болгон экспортлох олон тулгуурт эдийн засгийн тогтолцоог бүрдүүлэх замаар ажил эрхлэлтийг дэмжих, ядуурлын түвшнийг бууруулах, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих, төгрөгийн тогтвортой байдлыг хангах, шаардлага тулгараад байгаа юм.

Манай улсын аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь 1990 онд хамгийн их 41.21 хувь байсан бол түүнээс хойш огцом буурч, 2001 онд хамгийн бага 21.94 хувьд хүрсэн. Харин түүнээс хойш уул уурхайн салбарын нөлөөгөөр алгуур нэмэгдэж 2021 оны байдлаар 37.0 хувь хүрсэн. 2021 онд дэлхийн 138 орны дундаж үзүүлэлт 26.5 хувь байжээ. Мөнгөн дүнгээр илэрхийлбэл, манай улсын аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртөг 1993 онд хамгийн бага буюу 0.23 тэрбум ам доллар хүрч байсан бол 2019 онд хамгийн их буюу 5.41 тэрбум ам.доллар, 2020 онд 4.93 тэрбум ам.долларт хүрсэн.


Зураг 18. ДНБ-д аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь



Эх сурвалж: <https://www.theglobaleconomy.com/>

Үүнээс боловсруулах дэд салбарыг салгаж харвал, 1989 онд хамгийн их 32.7 хувь хүрч байсан тус салбар 2006 онд хамгийн бага буюу 5.43 хувьд хүрч унасан.

Зураг 19. ДНБ-д боловсруулах салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь



Эх сурвалж: <https://www.theglobaleconomy.com/>

Түүнээс хойш төдийлөн нэмэгдэж чадаагүй байгаа бөгөөд 2021 оны байдлаар дөнгөж 7.6 хувь байгаа юм. Гэтэл эдүгээ энэ үзүүлэлт дэлхийн 124 орны дундаж үзүүлэлт 13.04 хувь байгаа нь манай улс боловсруулах үйлдвэрлэлийн салбарын хөгжлөөр маш их хоцрогдож байгааг илтгэж байна. Мөнгөн дүнгээр илэрхийлбэл, 1989 онд 1.17 тэрбум ам.долларын нэмэгдэл өртөг бүтээж байсан энэ дэд салбарын нэмэгдэл өртөг 1999 онд 0.07 тэрбум ам.доллар болж унасан. Харин 2020 онд 1.03 тэрбум ам.долларт хүрсэн сэргэсэн боловч 1989 оны түвшиндээ хүрээгүй байна.

Монгол Улсын боловсруулах салбарын нэмэгдэл өртгийн 2019-2020 оны индекс үзүүлэлтүүдийг бусад улстай харьцуулахад ч нэлээд хоцрогдолтой байдаг. Тухайлбал, Хүснэгт 3-д харуулснаар, боловсруулах үйлдвэрийн өрсөлдөх чадварыг илэрхийлэх ихэнх үзүүлэлтээр манай улс харьцуулалт хийгдсэн 154 улсаас 100-аас хойш байр эзэлж байна. Өөрөөр хэлбэл, манай улсын боловсруулах үйлдвэрлэлийн салбар нийт үйлдвэрлэлийн хувьд ч, экспортын хувьд ч олон улсад өрсөлдөх чадвар маш муутай байгаа юм.


Хүснэгт 3. Боловсруулах үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварын индекс (154 улсаас)

Боловсруулах салбарын нэмэгдэл өртгийн индекс үзүүлэлтүүд	Эрэмбэ 2020	Оноо	Дэлхийн дундаж	Эрэмбэ 2019
Нэг хүнд ногдох үйлдвэрлэлийн нэмэгдэл өртгийн индекс	94	0.014	0.066	97
Үйлдвэрлэлийн нийт нэмэгдэл өртгийн индекс хөнгөн болон хүнд үйлдвэрлэлийн эзлэх хувь	98	0.271	0.330	101
Үйлдвэрлэлийн нэмэгдэл өртгийн индекс	138	0.045	0.302	138
Аж үйлдвэржилтийн индекс	128	0.158	0.316	128
Дэлхийн үйлдвэрлэлийн нэмэгдэл өртгийн индекс эзлэх хувь	117	0.000	0.021	122
Боловсруулах салбарын экспортын индекс үзүүлэлтүүд	Эрэмбэ 2020	Оноо	Дэлхийн дундаж	Эрэмбэ 2019
Нэг хүнд ногдох үйлдвэрлэлийн экспортын индекс	67	0.026	0.096	68
Нийт экспортын индекс боловсруулах салбарын экспортын эзлэх хувь	111	0.396	0.609	112
Үйлдвэрлэлийн экспортын нийт индекс хөнгөн болон хүнд үйлдвэрлэлийн эзлэх хувь	147	0.015	0.414	141
Аж үйлдвэрийн экспортын чанарын индекс	137	0.205	0.512	137
Дэлхийн үйлдвэрлэлийн экспортын индекс эзлэх хувь	91	0.001	0.034	93

Эх сурвалж: <https://stat.unido.org/>


Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын экспортыг тодруулж авч үзье. Монгол Улсад 2020 онд 7.6 тэрбум ам.доллар экспорт хийсний 95 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн эзэлжээ. Үлдсэн 5 хувь нь уул уурхайн бус бүтээгдэхүүний экспорт байна. 95 хувийг эзэлж буй уул уурхайн экспортыг задалж үзэхэд ихэнх нь нэмүү өртөг шингээгүй түүхий эд байгаа бол уул уурхайн бус экспортын 97 хувийг есөн төрлийн бүтээгдэхүүн бүрдүүлж байна. Эдгээр есөн бүтээгдэхүүний ганцхан нь бэлэн буюу ноосон, нэхмэл, ноолууран хувцас байгаа юм. Нөгөө талдаа, сүүлийн гурван жилд 1500 орчим аж ахуйн нэгж их, бага хэмжээгээр экспорт хийжээ. Гэхдээ нийт экспортын 70 орчим хувь нь 30 аж ахуйн нэгжээс хамааралтай байгаа бол тэдний ердөө хоёр нь л бэлэн бүтээгдэхүүн экспортолж байгаа юм. Мөн сүүлийн гурван жилд манай улс 82 улс руу экспорт хийсэн ч үүний 97 хувь нь 11 улс руу, хамгийн их нь буюу БНХАУ нийт экспортын 80 орчим хувийг эзэлж байна. 2021 оны байдлаарх экспортын барааг үйлдвэрлэлийн төрлөөр нь авч үзвэл дунджаар нийт экспортын орлогын 85-90%-ийг уул уурхайн салбараас дангаар нь бүрдүүлж байгаа нь мөн л эдийн засаг нэг салбараас хэт хамааралтай, туйлын эмзэг байдалд байгааг илтгэнэ. Экспортын орлогыг бүрдүүлж буй голлох улсыг дурдвал БНХАУ-тай 6.8 тэрбум ам.долларын худалдаа хийжээ. Энэ нь гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 67.3 хувийг эзэлж байна. БНХАУ-д экспортолсон бараа бүтээгдэхүүний 24.1 хувийг чулуун нүүрс, 39.6 хувийг зэсийн баяжмал эзэлж байгаа бол Швейцар улсад экспортолсон барааны 99.5 хувийг, БНСУ-д экспортолсон барааны 81.3 хувийг алт эзэлж байна.

Зураг 20. Уул уурхайн бус салбарын экспорт, 2019-2021 он



Эх сурвалж: <https://mofa.gov.mn/>

Зураг 21. Экспортын орлогод эзлэх хувь, улсаар, 2019-2021




Эх сурвалж: <https://mofa.gov.mn/>

Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын хөгжилд урт хугацаатай санхүүжилт маш чухал үүрэгтэй байдаг. Гэтэл манай улсын санхүүгийн салбар сул байдаг тул ялангуяа боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчдэд урт хугацаатай, хямд санхүүгийн эх үүсвэр олддоггүй. Жишээлбэл, нэрлэсэн зээлийн хүү гадаад худалдаа эрчимтэй хөгжсөн орнуудын хүүтэй харьцуулахад маш өндөр байдаг (Зураг 22). Монгол Улсын жижиг дунд үйлдвэр эрхлэгчид 2017 оны түүвэр судалгаанд санхүүжилтийн орчинд хамгийн их хүндрэл бий болгож буй хүчин зүйл нь зээлийн хүү байна гэж хариулжээ. Олон улсад

Засгийн газар экспортологч байгууллагын зээлийн хүртээмжийг сайжруулахын тулд хэд хэдэн аргаар хөндлөнгөөс санхүүгийн зах зээлд оролцдог байна. Ихэвчлэн жижиг компаниудад олгож буй голлох үйлчилгээ нь худалдааны санхүүжилт буюу зээлийн татаас олгох, зээлийн зах зээлийн өрсөлдөөнийг урамшуулах, экспортын хөнгөлөлттэй зээл олгох, зээлийн баталгаа олгох зэрэг юм. Манай оронд гадаад худалдааны санхүүжилтийн төрөлжсөн санхүүгийн байгууллага байхгүй байна. Монголбанкны судалгаагаар гадаад худалдааны санхүүжилтийн дийлэнх хувийг аккредитивийн зээл эзэлж байгаа бөгөөд экспортын аккредитивийн санхүүжилт бараг байхгүй, зөвхөн импортын аккредитивийн санхүүжилт багахан хэмжээтэй байгаа ажээ.

Зураг 22. Улс орнуудын нэрлэсэн зээлийн хүү



Эх сурвалж: <https://mongolbank.mn/>

Шинэ сэргэлтийн бодлого ба аж үйлдвэрийн салбар

Экспортыг төрөлжүүлж, орлогоо нэмэгдүүлж чадсан орнуудын туршлагаас үзэхэд, экспортын бодлого нь тогтвортой, хэрэгжүүлэх механизм нь тодорхой байсан учраас амжилттай хэрэгжиж байжээ. Манай Улсын хувьд нийт экспортын 95 хувийг эзэлж буй уул уурхайн экспортыг задалж үзэхэд ихэнх нь нэмүү өртөг шингээгүй түүхий эд байдаг. Тэгвэл ердөө тавхан хувийг эзэлж буй уул уурхайн бус эрдэс түүхий эдээс бусад бүтээгдэхүүний экспортыг өсгөх, төрөлжүүлэх зорилготой экспортыг дэмжих олон бодлого хөтөлбөрүүдийг авч хэрэгжүүлсэн ч дорвитой үр дүнгээ өгөөгүй хэвээр байна. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газар 1998 оны 158 дугаар тогтоолоор “Экспортын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр”-ийг 1998-2010 онд хэрэгжүүлэхээр баталсан. Гэсэн хэдий ч хэрэгжүүлэх механизм, санхүүгийн эх үүсвэрийг нь тодорхой заагаагүйгээс энэхүү хөтөлбөр бүрэн хэрэгжээгүй. Мөн Монгол Улсын Засгийн газраас 2013 онд баталсан “Экспортыг дэмжих хөтөлбөр”-ийн хэрэгжилт 18 хувь байсан.

Одоо хэрэгжиж эхлээд буй шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд энэхүү салбарт Аж үйлдвэржилтийг сэргээх гурван зорилт, 11 арга хэмжээг тусгасан бөгөөд энэ хүрээнд 13 төсөл, хөтөлбөр хэрэгжих ажээ. Байгалийн баялгаа боловсруулж, хүнс болон бусад хэрэгцээгээ дотоодын нөөц бололцоогоор хангаж, үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх, наад захын хэрэгцээгээ гадны зах зээлийн нөлөөнд оруулахгүй байх чадамжтай улс болоход “Шинэ сэргэлтийн бодлого”-ын зорилтууд хөшүүрэг болох байх гэсэн хүлээлт байна. Тухайлбал, уг бодлогод дараах зорилтуудыг дэвшүүлсэн.

- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг бүрэн цахимжуулж, өртөг зардлыг бууруулан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, дэвшилтэт техник, технологид суурилсан, нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээг дээшлүүлэн эрдэс баялгийн баталгаат нөөцийг арвижуулах

- Нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, дотоодын бүтээн байгуулалтын хэрэгцээг хангаж, экспортыг нэмэгдүүлэх
- Газрын тосны баталгаат нөөцийг өсгөж, олборлолтыг нэмэгдүүлэх замаар дотоодын газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэвшилтэт техник, технологи, инновацад тулгуурлан хөгжүүлж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ болон үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх
- Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нөөцтэй уялдуулан боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар хагас боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хувь хэмжээг бууруулан нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх
- Шинжлэх ухаанд суурилсан өндөр технологи, блокчейн, хиймэл оюун ухааны ололтыг нэвтрүүлж, дижитал эдийн засгийн чиг хандлагад нийцсэн аж үйлдвэржилтийг хөгжүүлнэ.

Аж үйлдвэржилтийн сэргэлтийн хүрээнд Оюутолгойн гүний уурхайн бүтээн байгуулалт эхэлсэн, 2023 оны эхний хагас жилээс бүрэн хүчин чадлаараа ажиллана. Эрдэнэт үйлдвэрийн зэсийн ордыг иж бүрэн ашиглах, Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах, Тавантолгой болон бусад нүүрсний ордыг иж бүрэн ашиглах, аж үйлдвэрлэл, технологийн парк цогцолбор барих, Дарханы арьс шир боловсруулах үйлдвэр, махны үйлдвэрүүд байгуулж, хөдөө аж ахуй, газар тариалан, хүнсний дотоодын хангамжийг сайжруулах зорилт тавьсан ба шинэ сэргэлтийн бодлого бүрэн хэрэгжсэнээр, ДНБ 2021 онд 43 их наяд байсан бол 2030 он гэхэд гурав дахин нэмэгдэж 120-150 их наяд, нэг хүнд ногдох ДНБ 2021 онд 4520 доллар байсан бол 10 жилийн дараа 12 мянган долларт хүргэхээр зорьж байгаа бөгөөд шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд нэмүү өртөг шингэсэн уул уурхай, тэр дундаа ган болон зэс боловсруулах үйлдвэр бол аж үйлдвэржилтийн энэ сэргэлтийн суурь нь болж байгаа юм.


2.4. Хот ба хөдөөгийн хөгжлийн асуудал

Хүн амын төвлөрөл, нүүдэл

Монголын нийгэмд явагдаж буй нэг гол өөрчлөлт бол хөдөөнөөс хот руу чиглэсэн нүүдэл, нийслэл дэх хүн амын хэт төвлөрөл юм. Энэ нь хөдөө орон нутагт хүний нөөц, зах зээл хумигдах, нийслэлд нийгмийн дэд бүтцийн ачаалал ихсэх байдлаар илэрч байна. Жишээлбэл,

Зураг 23-д харуулснаар, сүүлийн 20 жилд нийслэлийн хүн амын нийт хүн амд эзлэх хувь 32%-аас 46% болж нэмэгдсэн бол бусад бүсийн хүн ам, тэр дундаа Баруун бүсийн хүн амын эзлэх хувь 18%-аас 13%, Хангайн бүсийнх 23%-19% болж тус тус буураад байна.


Зураг 23. Хүн амын эзлэх хувь, бүсээр



Эх сурвалж: Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын нэгдсэн дүн, УСХ

Улаанбаатар хот руу шилжих хөдөлгөөнийг хязгаарлахын тулд нийслэлийн захиргаанаас 2017 онд шилжин ирэгсдэд бүртгэлийн хязгаарлалт тавьсан боловч энэ шилжилт хөдөлгөөн төдийлөн саараагүй.

Зураг 24. Бүсийн хооронд хүн амын шилжилт, 2015-2020 он




Эх сурвалж: 2020 оны Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнд үндэслэсэн судлаачийн тооцоо

Жишээлбэл 2015-2020 онд дотоодын шилжих хөдөлгөөнд орсон хүмүүсийн мэдээллээс харахад (Зураг 24) сүүлийн 5 жилд шилжигсдийн бараг тал хувь нь бусад бүсээс нийслэл рүү шилжигсэд байна.

Энэхүү хүн амын төвлөрлийн нэг гол шалтгаан нь сүүлийн жилүүдэд өрнөж буй эдийн засгийн бүтцийн өөрчлөлттэй холбоотой. Тухайлбал 1990-ээд онд манай улс төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцооноос зах зээлийн эдийн засагт шилжсэнээр аж үйлдвэрлэл уналтад орж хот суурин газрын хүн амын ажилгүйдэл нэмэгдсэн. Мөн социализмын үеийн хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуй тарснаар мал хувьчлагдаж, хөдөөг чиглэсэн ажиллах хүчний шилжилт эрчимтэй явагдсан. Зураг 25-д харуулснаар, 1990-ээд оны эхээр ХАА-н салбарын эзлэх хувь 12%-аас 38% болж огцом нэмэгдсэн боловч аажимдаа буурсаар 2021 онд 13% болоод байна. Хэдийгээр 30 жилийн хугацаанд малын тоо 3 дахин өссөн боловч бүтээмжийн өсөлт бараг гараагүй.

Зураг 25. Монголын эдийн засгийн бүтцийн урт хугацааны өөрчлөлт




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Сүүлийн 30 жилийн эхний 10 жилд хот суурин газраас хөдөөг чиглэсэн нүүдэл давамгайлж байсан бол 2000 оноос хойш хөдөөнөөс хот руу чиглэсэн нүүдэл давамгайлж байна. Үүний цаана хөдөлмөрийн зах зээл, нийгэм-соёлын үйлчилгээ, амьжиргааны түвшинтэй холбоотой эдийн засгийн шалтгаан бий. Ерөнхийдөө хүн амын төвлөрөл их байх тусам зах зээл бүрэлдэж, үйлдвэрлэл, үйлчилгээ төвлөрдөг. Үүнийг дагаад ажлын байр үүсэж, амьжиргааны түвшин дээшлэх магадлал нэмэгдэнэ.

Зураг 26-д харуулснаар 2014-2022 оны хугацаанд манай улсад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоо хоёр дахин нэмэгдсэн. Үүн дээр нэмээд Улаанбаатарт байрладаг аж ахуйн нэгжийн эзлэх хувь 61%-аас 69% болж өссөн нь нийслэл дэх аж ахуйн нэгжийн тоо улам бүр нэмэгдэж байгааг илтгэж байна.


Зураг 26. Үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Нийслэлд эдийн засаг, бизнесийн үйл ажиллагаа төвлөрч байгааг илтгэх бас нэг үзүүлэлт нь нийт ДНБ-д эзлэх нийслэлийн ДНБ-ний эзлэх хувь юм. Зураг 27-оос харахад Улаанбаатарын ДНБ нийт ДНБ-ий 63%-ийн бүрдүүлдэг бөгөөд сүүлийн 10 жил энэ байдал тогтвортой байна. Энэ хугацаанд Хангайн бүсийн ДНБ хувь нэмэр 16%-аас 14% болж буурсан бол Баруун бүсийнх 5%-6%, Зүүн бүсийнх 4%-5% болж нэмэгджээ. ДНБ-ий хувь нэмрийг бүтцээр нь харвал нийслэлийн ДНБ-ий дийлэнх нь үйлчилгээний салбараас ордог бөгөөд сүүлийн 10 жилд энэ байдал өөрчлөгдөж, үйлчилгээний эзлэх хувь буурч үйлдвэрлэлийн эзлэх хувь нэмэгдэж байна.


Зураг 27. ДНБ-д эзлэх салбаруудын хувь, бүсээр



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Дээрх хандлага ЖДҮ-ийн салбарт ч ажиглагддаг. ЖДҮ-ийн салбарын ДНБ-д оруулах хувь нэмэр Улаанбаатарт бусад бүсийнхээс өндөр байдаг бөгөөд сүүлийн жилүүдэд энэ хувь бас нэмэгдэж байгааг доорх зургаас харж болно.


Зураг 28. Бүсийн ДНБ-д ЖДҮ салбарын хувь нэмэр



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Хот хөдөөгийн эдийн засгийн орчны ялгаа нь өрхийн амьжиргаанд тусгалаа олдог. Тухайлбал харахад, Улаанбаатарт амьдардаг өрхүүдийн орлого бусад бүсийнхээс байнга өндөр, тэр хэрээр ядуурлын түвшин бусад бүсийнхээс байнга доогуур байж иржээ.

Зураг 29. Өрхийн амьжиргаа, бүсээр



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Бүс нутгийн хөгжлийн түвшин, бизнес эрхлэх боломж, амьжиргааны түвшин, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж ийм ялгаатай үед хөдөөнөөс хот руу чиглэсэн нүүдэл тасрахгүй бөгөөд энэ нүүдлийг механикаар хааж зогсоох нь үр дүнгүй шийдэл юм.

Бүс нутгийн тэнцвэрт хөгжлийг хангах зорилгоор олон жилийн турш төрөөс төвлөрлийг сааруулах, бүсчилсэн хөгжлийг дэмжих, хөдөө орон нутгийг хөгжүүлэх янз бүрийн бодлого зохицуулалт хэрэгжүүлж ирсэн. Жишээлбэл, 2006 онд УИХ-аас баталсан “Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д хот байгуулалт, барилгын хөгжлийн бодлого, бүс нутаг, хөдөөгийн бодлогыг тусгайлан тодорхойлж, 2016-аас 2021 он хүртэлх 15 жилийг хамарсан урт хугацааны үе шаттай зорилтуудыг дэвшүүлж байсан. Жишээлбэл, хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоог хөгжүүлж, хот, суурингийн оршин суугчдад таатай орчин бүрдүүлэх, орчин үеийн чанарын шаардлага бүхий барилга, шинэ нэр төрлийн барилгын материалын үйлдвэрлэл, нийтийн аж ахуйн салбарыг бий болгон хөгжүүлэх, хүн амын орон сууцны хангамжийг эрс сайжруулна. "Орон сууц" үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх, хот байгуулалтыг улам боловсронгуй болгож, барилгын шинэ нэр төрлийн бараа, хийцийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бүсчилсэн хөгжлийн төлөвлөлт, удирдлагыг боловсронгуй болгож, бүс нутгийн хөгжлийг түргэсгэх, Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын бүсийн эдийн засгийн өсөлтийг хөгжлийн хүчин зүйл болгож, Мянганы хөгжлийн

зорилтуудыг хэрэгжүүлэх, "Хөдөөгийн хөгжил" үндэсний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх, бүс нутгуудад мэдлэгт суурилсан эдийн засгийн үндэс суурийг тавих, хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг эрс багасгаж, бүс нутгуудад мэдлэгт суурилсан эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлж байсан.

Хот, хөдөөгийн хөгжил ба шинэ сэргэлтийн бодлого

- Нийслэл Улаанбаатар хотын нийтийн тээврийн чанар, стандартыг сайжруулан багтаамж ихтэй шинэ төрлийн нийтийн тээврийн хэрэгслийг үйлчилгээнд нэвтрүүлж, гол ба үндсэн авто зам, замын байгууламжийн сүлжээг өргөтгөн шинэчилж, олон түвшний уулзварыг байгуулан хүртээмжийг нэмэгдүүлж, авто замын түгжрэлийг бууруулах
- Шинэ суурьшлын бүс, дагуул хот, эдийн засгийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэд, аж ахуйн нэгжүүдийг цогц бодлогоор дэмжих замаар төвлөрлийг сааруулах.
- Аймгийн төвүүдийг бие даасан хот болгон хөгжүүлж, орон нутаг төсвийн орлогоо бие даан бүрдүүлэх санхүү, эдийн засгийн боломжийг бүрдүүлэх
- Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн бодлогод тулгуурлан мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг дэмжиж, хүнсний дотоодын хэрэгцээг ханган, экспортын хувь хэмжээг нэмэгдүүлэх.


2.5. Ногоон хөгжлийн сэргэлт

Өнөөгийн байдал

Дэлхий даяар аж үйлдвэржилт өргөжиж, эдийн засгийн хөгжлийн эрчим нэмэгдэхийн хирээр байгаль орчны бохирдол, хүлэмжийн хий нэмэгдэж, уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал нэмэгдэж, цөлжилтийн асуудал хурцаар тавигдаж эхлэв. Тухайлбал, эрдэмтдийн тооцоолсноор дэлхий нийтийн нүүрстөрөгчийн ялгаруулалт өнөөгийн хэмжээнд хэвээр үргэлжилбэл 2030 он гэхэд дэлхийн дундаж температур 1.5 градусаар дулаарах аж (Dual Citizen LLC, 2022). Улмаар дэлхий даяар байгальд ээлтэй, ногоон хөгжлийг дэмжих бодлогыг томьёолон хэрэгжүүлж байна.

Олон улсын Dual Citizen байгууллагаас 2005 оноос хойш дэлхийн нийт 160 улсын ногоон эдийн засгийн үзүүлэлтийг “Олон улсын ногоон эдийн засгийн индекс”-ээр тооцон нийтэд нээлттэй мэдээлж байна. Тус индексийг үндсэн дөрвөн 4 том бүлгийн 18 үзүүлэлтүүдийн хүрээнд тухайн шалгуурын өнөөгийн утгын 2005 оноос хойших өөрчлөлт болон олон улсын тогтвортой байдлын зорилтот түвшин хүртэлх зай гэх хоёр үзүүлэлтийг нэгтгэн тооцдог аж. Дараах зурагт Манай улсын ногоон эдийн засгийн индексийн утга болон 160 улсад эзэлж буй эрэмбийг харуулав.

Зураг 30. Ногоон хөгжлийн индекс, 160 улсад эзэлж буй эрэмбээр, 2020 он



Эх сурвалж: Dual Citizen LLC, <https://dualcitizeninc.com/global-green-economy-index/>

Ногоон хөгжлийн индексээс харахад манай улсын ногоон хөгжлийн үзүүлэлт нийт 100 онооноос 43.1 оноотой буюу дэлхийн 160 улсаас 125-р байранд эрэмбэлэгдэж байна. Индексийн задаргааг авч үзвэл 2005 оноос 2020 оны хооронд гарсан дэвшлийн оноо 65.3 буюу нийт 160 улсаас 11-р байранд эрэмбэлэгдэж байгаа ч дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн тогтвортой хөгжлийн зорилтот үзүүлэлтийн зөрүүний оноо 35.7 буюу 147-р байранд эрэмбэлэгдэж байна. Энэ нь 2005 оноос хойш манай улс ногоон эдийн засгийг дэмжих хүрээнд бусад улсуудтай харьцуулахад ахиц дэвшил гаргаж байгаа хэдий ч тогтвортой хөгжлийн зорилтот түвшинд хүрэхэд хангалтгүй байгааг харуулж байна. Энэхүү индексийн тооцоололд орсон зарим шалгуур үзүүлэлтүүд Тогтвортой хөгжлийн зорилт дахь түлхүүр үзүүлэлтүүдтэй ижил байгааг дурдах нь зүйтэй.

Ногоон хөгжлийн талаар баримталж буй бодлого, түүний хэрэгжилт

1998 онд анх Монгол Улсын 21-р зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр баталснаас хойш байгаль орчинд ээлтэй, ногоон эдийн засгийн хөгжлийн загварыг дэмжих бодлогыг урт хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгаж эхэлжээ. Түүнээс хойш 2005 онд Мянганы хөгжлийн зорилтууд, 2008 онд МХЗ-д суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого зэрэг баримт бичгүүдэд дэд зорилт, бүлэгт ногоон хөгжилд чиглэсэн зорилтуудыг тусгаж байжээ. 2012 онд нэгдсэн Тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэх хүрээнд 2014 оны 6-р сарын 13-нд анх удаа “Ногоон хөгжлийн бодлого” гэх бие даасан бодлогын баримт бичгийг батлав.

Тус баримт бичгээр ногоон хөгжил, ногоон эдийн засаг гэх нэр томъёонуудыг тодорхойлж, тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн. Тухайлбал, “Ногоон хөгжлийн бодлого”-т ногоон эдийн засаг гэж байгаль орчны эрсдэл, доройтлыг багасгахын зэрэгцээ хүний сайн сайхан байдал, нийгмийн тэгш хүртээмжтэй байдлыг сайжруулах зорилго бүхий эдийн засгийг хэлнэ гэж тодорхойлжээ (Монгол Улсын Их Хурал, 2014). Дараах хүснэгтэд тус хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн үндсэн 14 үзүүлэлтийн зорилтот түвшин болон тэдгээрийн хэрэгжилтийг харуулав.

Зураг 31. Тогтвортой хөгжлийн зорилтын зарим шалгуур үзүүлэлтийн өнөөгийн байдал ба зорилтот түвшин

Шалгуур үзүүлэлт	2013	2016	2018	2019	2020	2020*	2030*
ДНБ-д ХАА, Боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь	22.5	19,0	20.2	20.6	20.7	28	30
УБ хот болон бусад суурин газрын ногоон байгууламжийн эзлэх хувь	3.14	14.3	-	-	-	15	30
Ядуурлын түвшин	27.4	29.6	28.4	-	27.8'	24	15
Сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдах хүн амын эзлэх хувь	33.2	-	-	-	30.4'	40	60
Баталгаат ундны усаар хангагдах хүн амын эзлэх хувь	72.6	68.1	86.9	-	-	80	90
Нийт газар нутагт ойгоор бүрэгдсэн талбайн эзлэх хувь	8.0	7.9	7.9	7.96	-	8.5	9
Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хувь	-	-	-	-	-	20	30
Тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь	17.4	17.4	17.9	19.8	-	25	30
Засгийн газрын ногоон худалдан авалтын эзлэх хувь	-	-	-	-	-	20	30
ШУ технологийн судалгаанд зарцуулах ДНБ-д эзлэх хувь	0.8	0.04	-	-	-	2	3
Ногоон хөгжилд зарцуулах зардлын ДНБ-д эзлэх хувь	0.4	0.23	0.27	0.39	-	2	3
Хог хаягдлын дахин боловсруулалтын хэмжээ эзлэх хувь	15.7	8.9	7.2	7.2	7.9'	20	40
Барилгын дулаан алдагдлын бууралт хувь	-	-	-	-	-	20	40
Эрчим хүчний үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь	4.3	6.9	18.1	19.3		20	30

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Тогтвортой хөгжлийн зорилт, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, 2021; *зорилтот түвшин*

Дээрх хүснэгтээс харахад нийт 14 шалгуур үзүүлэлтээс нэг ч үзүүлэлт 2020 оны зорилтот түвшинд хүрээгүй байгааг харж болно. Түүнчлэн, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, статистикийг олон нийтэд тараасан албан ёсны тайлан, судалгааны ажил огт байхгүй байв. Улмаар 2021 оны 11-р сарын 12-ны өдөр тус баримт бичгийг хүчин болгожээ. НҮБ-ийн Байгаль орчны хөтөлбөрийн тайланд дурдсанаар Ногоон хөгжлийн бодлогоор байгаль орчинд чиглэсэн томоохон зорилтуудыг тодорхой томъёолсон нь амжилт болсон ч хэрэгжилтийн үнэлгээний аргачлал тодорхойгүй, хяналт үнэлгээний систем сул, үйл ажиллагааны санхүүжилт хангалтгүй, оролцогч талуудын бодлогын зорилгын талаар ерөнхий ойлголт сул, нийтэд мэдээлэх байдал хангалтгүй зэрэг хүндрэлүүдийн улмаас хэрэгжилт хангалтгүй байсныг дурджээ.

Үүний дараагаар дэлхий нийтийн хүртээмжтэй, ногоон эдийн засгийн чиг хандлагатай уялдан “Тогтвортой Хөгжлийн Үзэл Баримтлал 2030” (2016), “Алсын хараа-2050” (2020) зэрэг бодлого батлагдаж, ногоон хөгжлийн бодлогод чиглэсэн зорилтууд шинээр тусгагдаж байсан.

Ногоон хөгжил ба Шинэ сэргэлтийн бодлого

Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд ногоон хөгжлийн чиглэлд дараах зорилтуудыг дэвшүүлжээ


- Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад дорвитой хувь нэмэр оруулах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг үр дүнтэй өрнүүлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- Усны нөөцийг хамгаалж, хүн амыг баталгаат ундны усаар хангах, бэлчээрийг усжуулах, говийн бүс нутгийн усан хангамжийг нэмэгдүүлэх, саарал усыг дахин ашиглах, хиймэл нуур, хөв цөөрөм байгуулж, ширгэсэн гол горхи, булаг, шандыг нөхөн сэргээнэ.
- Байгальд ээлтэй дэвшилтэт технологи бүхий хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдийг аймаг, нийслэлд бүсчлэн байгуулна.
- Эдийн засаг, аж үйлдвэржилтийн сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэхдээ байгаль хамгаалах үндэсний уламжлалт ёс заншлыг хадгалж, дэлхийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн ногоон хөгжлийн жишиг загварыг тодорхойлно.


2.6. Төрийн бүтээмжийн сэргэлт

Төрийн бүтээмжийн өнөөгийн нөхцөл байдал

“Шинэ сэргэлтийн бодлого” -ын хүрээнд шийдвэрлэхээр зорьсон зургаан багц асуудлын нэг төрийн бүтээмжийн сэргэлт нь ил тод, цомхон чадварлаг төр, илүү сайн засаглал, шуурхай, хүртээмжтэй төрийн үйлчилгээг бий болгож, хувийн хэвшлийн зөөлөн дэд бүтэц, бизнес эрхлэхэд таатай орчин бүрдүүлэх чиглэлд төвлөрч байна. Төрийн албан хаагчдын тоо 2009-2021 оны хооронд 38.5%-аар өссөн. Энэ хугацааны төрийн албан хаагчийн тооны огцом өсөлтийг хүн амын өсөлттэй холбож болох ч энэ нь үндэслэлтэй тайлбар болж чадахгүй. Төрийн Албаны Зөвлөлийн 2021 оны тайлангаас харахад төрийн албан хаагчдын тоо 208864 (төрийн үйлчилгээний албан хаагч 66% бүрдүүлж байгааг дурдах нь зүйтэй), нийт ажиллах хүчинд эзлэх хэмжээ 17% хүрсэн бөгөөд төрийн албан хаагчдын цалин 2020 оны дүнгээр ДНБ-д 6% эзэлж байна. Нэг талаас энэ нь өргөн уудам нутаг дэвсгэрт тархсан хүн амд төрийн үйлчилгээг хүргэх нэгж өртөг өндөр байгаагийн илрэл юм.

Зураг 32. Төрийн албан хаагчийн тоо мянга, ажиллах хүчинд эзлэх %, цалингийн ДНБ -д эзлэх %





Эх сурвалж: Төрийн Албаны Зөвлөл, YCX 1212.mn

Төрийн албаны бүтэц, зохион байгуулалт, оновчтой бүтцийг тогтоон, албан хаагчдын тоог бууруулах үр дагавартай гэж үзэн 2022 оны 4 -р сарын 29 -нд “Төрийн хэмнэлтийн тухай” хуулийг баталсан. Уг хуульд тэргүүн дэд, дэд орлогч дарга, зөвлөх чиг үүрэг бүхий албан тушаалтны тоог тусгасан. Төрийн үйлчилгээг сайжруулж, төсвийн хэмнэлтийг хэрэгжүүлэх, нийтийн мэдээллийн дэд бүтцийг боловсронгуй болгож, цаасан суурьтай үйл ажиллагааг багасгах зорилгоор 2020 оны 10-р сарын 1 -ний өдөр нээлтээ хийсэн төрийн үйлчилгээний нэгдсэн систем болох E-Mongolia -аас давхардсан тоогоор 1.9 сая иргэн үйлчилгээ авч 64.5 тэрбум төгрөгийг хэмнэсэн гэж мэдэгдсэн. Гэвч боловсон хүчний зардал нэмэгдэж байгаа нь илүү үр дүнтэйгээр төрийн үйлчилгээ хүргэж, тогтвортой хөгжлийг хангахад зарцуулж болох нөөц бололцоог үгүй хийх хандлагатай. Хүн амд үйлчилгээ үзүүлэх төрийн алба том байх шаардлагатай юм бол төрийн албаны гүйцэтгэл, үр дүн өндөр байх шаардлагатай⁵ гэсэн зөвлөмж гарсан.

Монгол Улсын их хурлын 2021 оны 12-р сарын 17 -ны өдрийн нэгдсэн хуралдаанаар “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Цахим гарын үсгийн тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуулиудыг баталсан. Цахим шилжилтийн 2021 оны үр дүнг харвал, төр, бизнес, нийгмийн бусад салбаруудад цахим технологи суурьшуулсан байдлыг 3 хүчин зүйл 52 шалгуураар харгалзан тооцсон үзүүлэлтээр 64 орноос 62 -т жагсаж байна.


Зураг 33. Цахим өрсөлдөх чадварын индекс, жагсаалтад эзэлж буй байр



⁵ Дэлхийн Банк, Өндөр чадавхтай төрийн албыг бий болгох нь: Шинэтгэлийн явц, сургамж, 2020.

Эдгээр хуулиуд цахим шилжилт хийх эрх зүйн орчин бүрдүүлснээс гадна, 5 төрлийн 68 мэдээлэл ил болсноор авлигын түвшинг бууруулах боломж бүрдэнэ. Авлига, хүнд суртал, УИХ, орон нутгийн сонгуулийн дараах албан хаагчдын шилжих хөдөлгөөн нэмэгдэх зүй тогтол төрийн албаны чанарыг бууруулж Монгол улсын хөгжлийг хойш чангаасаар байгаа асуудал мөн. Монгол улсад 2019-2021 оны хооронд авлигын түвшин буураагүй буюу хэмжүүр үзүүлэлт огт сайжраагүй, дэлхийн 180 орноос 110 -т жагсаж байна.


Зураг 34. Авлигын түвшин, жагсаалтад эзэлж буй байр



Эх сурвалж: Transparency International, [transparency.org](https://www.transparency.org)

Монгол Улсын их хурлын 6 -р сарын 17 -ны хуралдаанаар 2023 оны 1 сарын 1 -ээс дагаж мөрдөхөөр баталсан “Зөвшөөрлийн тухай” хуулийн хүрээнд тусгай зөвшөөрлийн тоог бууруулж, холбогдох үйл явцын хугацааг богиносгож цахимжуулах, мэдээллийг нээлттэй ил тод болгох нөхцөл бүрдүүлсэн нь авлигын түвшин буурах, төрийн бүтээмж нэмэгдэх хүлээлтийг бий болгосон. Хуульд зааснаас бусад чиглэлд тусгай зөвшөөрөлгүйгээр эрхлэх үйл ажиллагааг нээлттэй үлдээж, төлөвлөгөөт хяналт шалгалтын тоог бууруулснаар бизнесийн орчин сайжирна гэж үзэж байна. Бизнесийн орчны хувьд дэлхийн 190 улсаас Монгол улс 81 -р байранд байна.

Зураг 35. Бизнесийн орчны үзүүлэлт, эзэлж буй байр, бусад үзүүлэлт, 2012-2019 он






Эх сурвалж: World Bank

Шинээр бизнес эхлүүлэх, дампуурлыг шийдвэрлэх, хил дамнасан худалдаа хийх, цахилгаанд холбогдохтой асуудлууд бизнесийн орчинд тулгамдаад байна. “Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим” -аас эрхлэн гаргасан “Монголын Бизнесийн Орчин 2020” судалгааны тайланд шинээр бизнес эрхлэхэд эрхлэхэд хүндрэлтэй, эхлүүлэх хөрөнгө санхүүжилт дутагдалтай, бизнес эхлүүлэх зардлыг зардлыг гаргахад хүндрэлтэй, авдаг техникийн нөхцөл, зөвшөөрлийн процесс төвөгтэй, хүнд сурталтайг онцолжээ. Ялангуяа, ажлын байр их шингээдэг худалдаа, үйлчилгээний салбарт шинээр бизнес эрхлэхэд шаарддаг шалгуур, стандарт, зөвшөөрөл хүндрэлтэй гэж аж ахуй нэгжүүд мэдэгдсэн. Хил дамнасан худалдааны хүрээнд бизнесүүдийн 72.9% төрийн зүгээс бодлогоор тууштай дэмжих шаардлагатай гэж үзэж байна. Мөн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид бизнесээ бүртгүүлэх, зөвшөөрөл хүсэх, тайлагнах, мэргэжлийн хяналтын шаардлага биелүүлэх зэрэг үйлчилгээнд дунджаар орлогынхоо 4.4% -тай тэнцэх хэлцлийн зардал гаргаж байгаа нь хүнд сурталтай тулгардгийн илрэл юм (Манлайбаатар, Нарантуяа & Гансүлд, 2016).

Зураг 36. Нийт хэлцлийн зардлын ачааллын харьцуулалт %



Эх сурвалж: Манлайбаатар, Нарантуяа, & Гансүлд. (2016), Жижиг дунд үйлдвэрийн хэлцлийн зардлын судалгаа


Зураг 37. Төрийн байгууллагын үйлчилгээний хүнд суртлын индекс. 2018, доогуур утгатай байгууллагууд



Эх сурвалж: МҮХАҮТ, Хүнд суртлын индекс судалгааны тайлан, 2018

Төрийн үйлчилгээний чанар, төрийн албаны улс төрийн дарамтаас ангид үйл ажиллагаа явуулах түвшин, бодлого боловсруулах, уг бодлогын биелэлтийг харгалзан гаргадаг төрийн үр ашгийн индекс дэлхийн дундаж (-0.03) -аас доогуур буюу -0.34 байна. Эндээс, засаглалыг хэрэгжүүлж буй институцын чанар, төрийн албаны бүтээмж муу гэсэн дүгнэлтэд хүрч болно.

Зураг 38. Засгийн газрын үйл ажиллагааны үр дүнгийн индекс. 2020



Эх сурвалж: World Bank, GovData360.worldbank.org

Төрийн бүтээмжийн сэргэлт

2021 оны 12-р сард УИХ-аас баталсан Шинэ сэргэлтийн бодлогод төрийн бүтээмжийг дээшлүүлэх чиглэлээр дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- Төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулах
- Засгийн газрын бүтэц, зохион байгуулалтад цогц шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгч, оновчтой бүтцийг тогтоон, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод шилжүүлэх
- Төрийн хяналт, шалгалтын давхардсан тогтолцоог цэгцэлж, төлөвлөгөөт шалгалтыг түр хугацаанд зогсоон, төрийн байгууллагаас шаарддаг тусгай зөвшөөрөл, техникийн нөхцөлийн тоог бууруулах
- Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулах
- Авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгах

- Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/-аас гаргадаг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улсын жагсаалт /саарал, хар жагсаалт/, Европын холбооны "Татварын зорилгоор хамтран ажилладаггүй бүс нутгуудын жагсаалт"-д орохгүй байх, түүнчлэн Монгол Улсын зээлжих зэрэглэлийг бууруулахаас сэргийлнэ.

3. Дүгнэлт, зөвлөмж

УИХ-аас 2021 оны 12-р сард баталсан Шинэ сэргэлтийн бодлого нь эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж буй хүчин зүйлсийг даван туулахад чиглэсэн, Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлогын суурь нөхцөлийг хангахад чиглэсэн 2030 он хүртэл хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө юм.

Хэдийгээр Шинэ сэргэлтийн бодлогод дэвшүүлсэн зорилтууд, бодлогын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төслүүд нь эдийн засгийн салбаруудын болон Засгийн газрын урьд өмнө дэвшүүлж ирсэн бодлого, хөтөлбөрүүдэд дэвшүүлж байсан зорилтуудтай давхцаж байгаа, тэдгээрийг дахин томъёолсон хэлбэртэй боловч энэ бодлогын онцлог нь “өсөлтийн оношилгоо” (growth diagnostic) хэмээх эдийн засгийн түгээмэл хэрэглэдэг арга зүйд үндэслэснээрээ чухал давуу далтай болсон. Өөрөөр хэлбэл, Засгийн газар эдийн засгийн дунд ба урт хугацааны хязгаарлагч гол хүчин зүйлсийг эхэлж тодорхойлоод, энэ хязгаарлалтуудыг арилгахад чиглэсэн алхам байдлаар урьд өмнө дэвшүүлж ирсэн бодлогуудыг шинээр бүлэглэж томъёолсноороо онцлогтой. Эдгээр хязгаарлагч хүчин зүйлс нь яах аргагүй манай улсын эдийн засгийн өсөлт, хөгжилд олон жилийн турш тулгамдаж ирсэн асуудлууд болох нь бидний шинжилгээнээс харагдаж байна.

Гэхдээ гол асуудал нь Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд төлөвлөсөн багц зорилтууд, 94 төсөл арга хэмжээг ач холбогдлоор нь эрэмбэлэх, хамгийн чухлаас эхэлж хэрэгжүүлэхэд нөөцийг хуваарилах явдал юм. Сүүлийн хоёр жил үргэлжилсэн Ковид-19 цар тахалтай тэмцэх, хохирлыг бууруулах чиглэлээр ихээхэн нөөц бололцоогоо шавхсан, угаас эдийн засгийн болон институцийн чадавх султай улсын хувьд бодлого хөтөлбөрүүдийг эрэмбэлж, өсөлтийг хамгийн их хязгаарлаж байгаа саадыг арилгах, хөрөнгө ба цаг хугацаа хамгийн бага шаардах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай.

Үүнээс гадна урьд өмнө дэвшүүлж байсан томоохон бодлого, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд тулгарсан бэрхшээл, сургамжийг харгалзан үзэх нь чухал. Тухайлбал, бодлогын зорилтуудын хүрээнд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, хэрэгжилтийн үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд, түүнийг үнэлэх аргачлал, үнэлгээний нэгж зэргийг нарийвчлан, бодитой тодорхойлох хэрэгтэй. Мөн бодлогын хэрэгжилтэд оролцогч талуудын оролцоо, чиг үүргийг нарийн тодорхойлж, оролцогч талуудын ойлголтыг нэмэгдүүлэх хэрэгцээтэй байдаг. Бодлогын хэрэгжилтийг үр дүнтэй болгох нэг чухал стратеги нь бодлогын хэрэгжилтийг олон нийтийн хяналтад оруулах буюу олон нийтэд тогтмол хугацаанд нээлттэй мэдээлэх явдал байдаг. Бодлогын зорилтот үр дүнгийн явц, хэрэгжилтийг нийтэд нээлттэй мэдээлэх, үүнийг тойрсон олон нийтийн хэлэлцүүлэг өрнөснөөр хэрэгжүүлэгч талуудын хариуцлага сайжрах эерэг нөлөөтэй байдаг.

Ашигласан эх сурвалж

- ADB. (2018). *Монгол Улсын тээвэр логистикийн салбарын хөгжлийн тухай*. Улаанбаатар: ADB.
- Dual Citizen LLC. (2022). *Global Green Economy Index*. Dual Citizen: <https://dualcitizeninc.com/global-green-economy-index/>-ээс Гаргасан
- Hausmann, R., Rodrik, D., & Velasco, A. (2005). *Growth Diagnostics*.
- Ianchovichina, E., & Gooptu, S. (2007). *Growth Diagnostics for a Resource-Rich Transition Economy: The Case of Mongolia*. *World Bank Policy Research Working Paper 4396*.
- Rodrik, D. (2004). *Why We Learn Nothing from Regressing Economic Growth on Policies*. Cambridge MA: Harvard University.
- The World Bank. (2018). *Connecting to Compete 2018: Trade Logistics in the Global Economy*. Washington, DC: World Bank.
- The World Bank. (2020). *Doing Business 2020: Comparing Business Regulation in 190 Economies*. Washington, DC: World Bank.
- Монгол Улсын Их Хурал. (2014 оны 6-р сар 13). *Ногоон хөгжлийн бодлого*. https://sdg.1212.mn/Content/files/Green_development_decision.pdf-ээс Гаргасан
- Олон улсын эрчим хүчний холбоо. (2021). *Дэлхийн эрчим хүчний тойм- 2021*. Олон улсын эрчим хүчний холбоо.
- ҮСХ. (2019). *Гадаад худалдаа 2019*. Улаанбаатар: ҮСХ.
- ЭЗСЭШХ. (2014). *5-р Цахилгааны Станцын Монголын эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ*. Улаанбаатар: Эдийн засгийн судалгаа эрдэм шинжилгээний хүрээлэн.
- Эрчим хүчний зохицуулах хороо. (2019 оны 5 29). *СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНЭ ДЭЛХИЙН ЗАХЗЭЭЛ ДЭЭР БУУРЧ БАЙГАА Ч МОНГОЛ УЛСАД НЭМЭГДЭЖ БАЙНА*. Эрчим хүчний зохицуулах хороо: <https://erc.gov.mn/web/mn/news/284>-ээс Гаргасан
- Эрчим хүчний зохицуулах хороо. (2022). *Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд 2021*. Улаанбаатар: Эрчим хүчний зохицуулах хороо.